



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ 86.1 ХУВЬТАЙ БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн: Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг дарга, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ

ДАРХАН-УУЛ АЙМАГ

2024 оны 06 дугаар сар

Аудитын зорилго, зорилтууд:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий дараах байгууллагууд хамрагдсан.

- Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-Төсвийн тухай хууль холбогдох журамд заасны дагуу төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах харилцааг зохицуулах чиг үүрэгтэй
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ОНӨГ-ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй
- “ДХББЗГ” ОНӨААТҮГ – Хуулийн дагуу захиалагч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хяналтын үүргийг гүйцэтгэх чиг үүрэгтэй
- Тендерт шалгарч, ажил гүйцэтгэсэн 31 гүйцэтгэгч байгууллага хамрагдсан болно.

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДСАН БАЙНА.

Төсөл, арга хэмжээний 96.5 хувь нь төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.

Аймгийн Засаг даргад 2023 онд шинээр УТХО-аар хэрэгжүүлэхээр салбар яамдаас эрх шилжүүлсэн 4,481.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам”-ын дагуу төлөвлөж, хөрөнгө оруулалтын удирдлагын www.pimis.mn цахим системээр үнэлсэн байна.

Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг Ковид 19 цар тахлын улмаас 6,337.2 сая төгрөгөөр нэмж, санхүүжилтийг олгосон байна.

Аудитаар 2018-2021 онд хэрэгжсэн 5 ТЕЗ-д хамаарах 14 ТАХ-ний 116,720.3 сая төгрөгийн төсөвт өртгийг Ковид19 цар тахлын улмаас үүссэн барааны үнийн зөрүү 6,337.2 сая төгрөгөөр нэмж, санхүүжилтийг олгосон байна.

Төсөл, арга хэмжээний 75.8 хувийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгожээ

Дархан-Уул аймагт төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн болон шинээр эхлэх нийт 43 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үндэслэн 70,670.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь нийт санхүүжилтийн 75.8 хувь байна.

БҮЛЭГ Б.ТАЙЛАНТ ХУГАЦААНД 17 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 23 АЖИЛ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

Цаг агаарын байдлаас шалтгаалж батлагдсан төсөл арга хэмжээний 52 хувийг гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна

Аудитаар батлагдсан нийт 43 ТАХ-г төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлсэн байдлыг тулгахад 17 ТАХ-ний 23 ажил хугацаандаа хэрэгжээгүй байна.

Энэ нь ТАХ-ний ихэнх хувийг цаг агаарын байдал хур тунадас ихтэй, цочир хүйтэрсний улмаас гадна зам талбайн тохижилтын ажлууд хийгдэх боломжгүй болсон тул Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоолын хүрээнд тус арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгө оруулалтын дансанд байршуулж, дараа онд гүйцэтгэлийг хангуулж санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн байна

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл оролцуулаагүй байна

Аймгийн Засаг даргын 2019 оны 01-А/29 дугаар захирамжаар авто зам, замын байгууламжийн барилгыг ашиглалтад оруулах комисс, 2021 оны 01-А/313 дугаар захирамжаар барилга байгууламж, гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын байнгын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг оролцуулахаар тус тус баталсан байна.

Гэтэл 17 ТАХ-ний комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл оролцуулаагүй байна.

Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаагүйгээс төрийн өмч, хөрөнгө эзгүйдэх, хөрөнгө оруулалтын үр дүн буурах эрсдэлтэй байна

Аудитаар нягтлан бодох бүртгэлд тусгаагүй 33,783.5 сая төгрөгийн барилга байгууламж, 2,302.4 сая төгрөгийн их засвар, 1,139.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 37,225.0 сая төгрөгийн 23 ТАХ-ний 31 ажил байна.

БҮЛЭГ В. ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 75.0 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

Дархан-Уул аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 сайдын багцын 12 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд 2 ТАХ ажлаа эхлүүлээгүй байна

Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж дууссан 12 ТАХ-г улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь дараах үр дүнд хүрсэн байна.

- Дархан сумын 15 дугаар багт үерийн усны хамгаалалт хийснээр 2,618 өрхийн 8,778 иргэн шар усны үерээс бүрэн хамгаалагдсан.
- Хонгор сумын цэвэрлэх байгууламжийн засвар шинэчлэлийн хүрээнд дотор засал, халдваргүйжүүлэх хэт ягаан туяаны төхөөрөмж, агааржуулах диффузер, агаарын насос, суурилуулснаар хүчин чадал 180-200м³ бохир цэвэрлэж хүчин чадал 50.0-66.7 хувиар нэмэгдсэн, албан хаагчдын эрүүл мэндийг анхаарч, ажлын байрны орчин сайжирсан зэрэг үр дүнтэй ажил болсон.
- Дархан-Уул аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар, Соёл урлагийн газар шинэ байртай болсноор албан хаагчид ажиллах таатай нөхцөл, орчин бүрдсэн.

Хонгор сумын Салхит багийн 499 өрхийн 1,628 иргэд оршин сууж байгаа бөгөөд багийн судалгаагаар СӨБ-д хамрагдаагүй 2-5 насны 140 хүүхэд байна. УТХО-аар баригдсан цэцэрлэгийг ашиглалтад оруулснаар дээрх багийн сургуулийн өмнөх

боловсролд хамрагдаагүй хүүхдийн 71.4 хувийг хамруулж, 22 ажлын байр шинээр бий болж сумын иргэдийн нийгмийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх үр дүнтэй ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

БҮЛЭГ Г.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичигтэй уялдуулан төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг шалгахад Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө зэрэг хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн төлөвлөсөн байна. Эдгээр хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд нь “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих жагсаалтад батлагдсан ТАХ-г байгууллагын санал, хэрэгцээ шаардлагад үндэслэн үр ашигтай байхаар төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө, сумдын ИТХ-ын төлөөлөгч, төрийн болон төрийн бус байгууллага, улс, орон нутгийн төсөвт байгууллага, 87 иргэнээс ирүүлсэн саналд үндэслэн холбогдох аргачлал, шалгуур үзүүлэлтээр үнэлж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэн 106 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тусгасан байна

Төсөл, арга хэмжээний урьдчилсан саналын жагсаалтыг сум, багийн түвшинд иргэд, олон нийтэд танилцуулж, ирүүлсэн саналыг эрэмбэлэн 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийсэн байна.

Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих ТАХ-г бүрэн тусгаж, төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 63 ТАХ-ээс өнгөрсөн онд бүрэн дууссан 39 ТАХ-ний чанарын баталгааны 598.7 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсныг төлөвлөж баталсан бол үргэлжлэн хийгдэх 2,762.3 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ нь өмнөх оноос шилжиж ирсэн 2,762.3 сая төгрөгийн 24, шинээр хэрэгжих 8,305.3 сая төгрөгийн 106 төсөл, арга хэмжээний, зураг төсвийг бодитой, төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсантай холбоотой байна.

БҮЛЭГ Д.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан нийт төсөл, арга хэмжээний 82.8 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.

Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 61.6 хувийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгожээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд нийт 169 төсөл, арга хэмжээг 11,663.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, 9,064.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Эдгээр төсөл, арга хэмжээнд нийт 11,666.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоос шинээр 78 төсөл, арга хэмжээнд 5,205.1 сая, өмнөх онд хэрэгжүүлсэн 17 төсөл, арга

хэмжээнд 1,976.2 сая төгрөгийг тус тус олгож, 4,485.0 сая төгрөгийн 29 ТАХ огт хэрэгжээгүй байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан худалдан авалтын 62.5 хувь нь амжилтгүй болж, шууд гэрээ байгуулсан байна.

Төлөвлөгөөнд нийт 8,035.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Батлагдсан төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулахдаа 84.2 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 15.8 хувийг харьцуулалтын аргаар зохион байгуулснаас 10 нээлттэй тендерт гүйцэтгэгч шалгараагүй тул гэрээ шууд байгуулж, бусад ХАА-г төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.

Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс төсөл арга хэмжээ дутуу хийгдсэн байна.

Аудитаар бүрэн дууссан ажлын гүйцэтгэлийг дахин шалгахад “ДХББЗГ” ОНӨААТҮГ нь 47.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний дутуу хийгдсэн ажлын гүйцэтгэлийг 100 хувь гэж дүгнэсэн байна.

Мөн “ДХББЗГ” ОНӨААТҮГ-т чанаргүй хийсэн 129.9 сая төгрөгийн 5 ТАХ-ний ажлуудыг гүйцэтгэгч байгууллагаар дахин засварлуулж, ашиглалтын байдлыг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн.

Бүрэн хэрэгжсэн 695.5 сая төгрөгийн 8 ТАХ-г бүртгэлд тусгаагүйгээс төрийн өмч, хөрөнгө эзгүйдэх, хөрөнгө оруулалтын үр дүн буурах эрсдэлтэй байна

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01-А/99 дугаар захирамж, аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд ашиглалтад орсон 7,265.4 сая төгрөгийн 33 ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тогтоосноор холбогдох байгууллагууд бүртгэлд тусгасан байна.

Харин холбогдох шийдвэр гараагүй 695.5 сая төгрөгийн 8 ТАХ-г бүртгэлд тусгаагүй байна.

БҮЛЭГ Е.3. ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 97.2 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 97.2 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

Дархан-Уул аймагт 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 хөтөлбөрийн хүрээнд 70 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссанаас 4,426.3 сая төгрөгийн 69 ТАХ-г зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна

ОНТХО-аар нийлүүлэгдсэн бараа материал, тоног төхөөрөмж ашиглагчийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаач төлөвлөгөөний хэрэгжилт 66.0 хувьтай байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Монгол Улсын болон аймгийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, газар, албадаас хэрэгцээ, шаардлага, тулгамдсан асуудал, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэгт үндэслэн боловсруулсан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр 106 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл 66.0 хувь буюу тайлант онд 70 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Зураг, төсвийг үндэслэлтэй хийгээгүйгээс ТАХ чанаргүй хийгдэх, хэрэгжихгүй байх шалтгаан болж байна.
- 2018-2021 онд хэрэгжсэн 14 ТАХ-ний төсөвт өртгийг Ковид 19 цар тахлын улмаас үүссэн барааны үнийн зөрүү 6,337.2 сая төгрөгөөр нэмж, төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна.
- ТАХ-ний 68.5 хувийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгожээ
- Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын тавих хяналт хангалтгүй байна.
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг оролцуулах шаардлагатай байна.
- Хэрэгжиж дууссан ТАХ-г нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй улмаас төрийн өмч, хөрөнгө эзгүйдэх эрсдэлтэй байна.
- Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 86.1 хувь нь зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж, иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичигтэй уялдуулан төлөвлөжээ.
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 43 дугаар тогтоолоор баталсан ТАХ-ний дүн 170.9 сая төгрөгийн зөрүүтэй батлагдсан байна.
- Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих ТАХ-г бүрэн тусгаж, төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.
- Нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан худалдан авалтын 62.5 хувь нь гэрээ шууд байгуулсан байна.
- Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн хяналтыг дутуу хэрэгжүүлж, зарим ажлыг бодитой тайлагнаагүй байна
- ОНТХО-аар нийлүүлэгдсэн бараа материал, тоног төхөөрөмж ашиглагчийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа ч төлөвлөгөөний хэрэгжилт 66.0 хувьтай байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга Б.Азжаргал танаа:

1. ТАХ-ний зураг, төсвийг үндэслэлгүй хийсэн гүйцэтгэгч байгууллагатай хариуцлага тооцон ажиллах
2. Ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг оролцуулах
3. Төрийн өмч хөрөнгө, эзгүйдэхээс урьдчилан сэргийлж, хөрөнгийн эзэмшигчийг тогтоон, 37,225.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгуулах
4. Шинэ хөдөө төслийн тоног төхөөрөмжүүдийг түрээсээр ашиглуулах журам, аюулгүй ажиллах зааврыг баталж, мөрдүүлж ажиллах
5. Аймгийн ИТХ-ын тогтоолын төсөлд тавих хяналтыг сайжруулах.
6. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанарын баталгааг ажлын гэрээнд заасны дагуу суутгаж байх
7. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд заасны дагуу төсөвт тодотгол, зохицуулалт хийсэн тухай бүр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусгаж, цахим системд байршуулах

Дархан-Уул аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Б.Баасанжаргал танаа:

1. Журамд заасны дагуу үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг бүрэн гаргуулж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд бүрэн мэдээлж, худалдан авах ажиллагааны баримт бичгийн цахим архив үүсгэх

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Бат-Эрдэнэ танаа:

1. Санхүүгийн жилд багтаан хөрөнгийн эзэмшигчийг тогтоох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлах, нягтлан бодох бүртгэлд тусгуулах ажлыг зохион байгуулах

Аймгийн “ДХББЗГ” ОНӨААТҮГ-ын дарга Д.Батбаяр танаа:

1. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын тавих хяналтыг сайжруулан, батлагдсан төсвийн дагуу ТАХ-г гүйцэтгүүлэх, төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлыг захиалагчид мэдэгдэж ажиллах

Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудын явцын хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийг үнэн зөв гаргаж ажиллахад анхаарч ажиллах

Аудитаар нийт 41,512.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийлгэх 155.9 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлэн, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 41,356.7 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөн.